



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/122/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn
Аудитор: Л.Равдандорж
Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.24 № 16/96

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Г.АНХБАЯР
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

440020499

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>485,284,783.41</u>	<u>691,189,128.47</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	324,750.00	3,100,650.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	324,750.00	3,100,650.00
3121	Төгрөг	324,750.00	3,100,650.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	324,750.00	3,100,650.00
33	АВЛАГА	36,696,853.00	40,161,631.33
335	Бусад авлага	36,696,853.00	40,161,631.33
3351	Байгууллагаас авах авлага	27,327,011.00	32,938,769.33
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,369,842.00	7,222,862.00
35	БАРАА МАТЕРИАЛ	448,263,180.41	647,926,847.14
351	Түүхий эд материал	161,222,306.21	296,069,421.61
35130	Эм боох материал	161,222,306.21	296,069,421.61
354	Хангамжийн материал	287,040,874.20	351,857,425.53
35410	Бичиг хэргийн материал	3,425,559.40	4,787,574.70
35420	Аж ахуйн материал	275,130,817.06	333,289,351.63
35430	Сэлбэг хэрэгсэл	5,250,500.00	5,992,750.00
35440	Түлш, шатах тослох материал	1,746,349.74	2,254,712.20
35460	Хүнсний материал	1,487,648.00	5,533,037.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,522,878,520.12</u>	<u>10,954,400,133.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,522,878,520.12	10,954,400,133.27
392	Биет хөрөнгө	8,977,276,540.95	10,408,963,154.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,398,230,500.00	7,760,240,894.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-242,722,153.35	-454,716,650.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	357,390,300.00	401,539,590.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-265,106,147.53	-206,212,253.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,558,636,605.05	9,303,811,999.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,996,555,210.53	-6,574,742,631.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	357,719,436.81	384,221,076.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	-191,853,121.50	-205,178,870.74
39217	Ном	1,536,332.00	00.00
393	Биет бус хөрөнгө	545,601,979.17	545,436,979.17
39301	Программ хангамж	2,195,000.00	2,195,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,543,020.83	-1,708,020.83
39303	Бусад биет бус хөрөнгө	544,950,000.00	544,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,008,163,303.53</u>	<u>11,645,589,261.74</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>436,995,368.18</u>	<u>183,833,723.54</u>
413	Өглөг	436,995,368.18	183,833,723.54
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,047,430.14	00.00

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	424,947,938.04	165,072,526.54
4136	Бусад өглөг	00.00	18,761,197.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	18,761,197.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,571,167,935.35	11,461,755,538.20
51	Засгийн газрын хувь оролцоо	9,571,167,935.35	11,461,755,538.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,532,071,275.49	4,532,071,275.49
51101	Өмч: - төрийн	4,532,071,275.49	4,532,071,275.49
512	Хуримтлагдсан үр дүн	-316,648,916.06	1,573,938,686.79
51210	Өмнөх үеийн үр дүн	-316,648,916.06	-316,648,916.06
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,890,587,602.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,355,745,575.92	5,355,745,575.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,008,163,303.53	11,645,589,261.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,399,169,600.00	11,590,247,907.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,732,777,278.29	2,887,704,613.78
120	Нийтлэг татварын бус орлого	229,368,445.69	2,887,704,613.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	223,888,445.69	2,881,168,713.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159,205,435.00	265,841,533.74
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64,683,010.69	164,833,366.74
120009	Бусад орлого	5,480,000.00	6,535,900.00
122	Тусламжийн орлого	2,503,408,832.60	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,503,408,832.60	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,666,392,321.71	8,702,543,294.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,271,334,600.00	4,538,634,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,271,334,600.00	4,538,634,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	171,127,897.71	523,825,539.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	300,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	67,287,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	438,507,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,127,897.71	17,729,839.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,223,929,824.00	3,640,083,155.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,223,929,824.00	3,640,083,155.00

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,742,335,812.54	9,564,351,971.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,742,335,812.54	9,564,351,971.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,726,403,805.07	9,540,240,872.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,847,639,655.00	4,766,898,018.00
210101	Үндсэн цалин	2,006,319,886.00	2,163,795,545.00
210102	Нэмэгдэл	1,541,468,389.00	2,164,316,134.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	176,257,500.00	176,415,000.00
210104	Урамшуулал	123,593,880.00	262,371,339.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	496,230,312.36	613,353,359.23
210201	Тэтгэврийн даатгал	345,585,032.65	384,955,658.47
210202	Тэтгэмжийн даатгал	40,108,499.78	58,202,457.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,855,439.82	47,508,650.96
210204	Ажилгүйдлийн даатгал	7,201,397.59	11,080,408.19
210205	Эрүүл мэндийн даатгал	72,479,942.52	111,606,184.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	908,506,454.82	940,760,711.20
210301	Гэрэл, цахилгаан	97,426,472.82	121,585,182.20
210302	Түлш, халаалт	644,586,530.00	651,606,202.00
210303	Цэвэр, бохир ус	166,493,452.00	167,569,327.00
2104	Хангамж, бараа материалын зардал	155,508,262.47	157,023,193.38
210401	Бичиг хэрэг	11,724,125.00	15,879,500.00
210402	Тээвэр, шатахуун	57,215,483.74	42,071,374.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,484,270.11	6,605,456.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,840,777.78	26,173,440.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,382,334.36	31,857,506.00
210408	Бараа материал акталсны зардал	22,861,271.48	34,435,915.55
2105	Нормативт зардал	1,801,740,662.03	1,939,683,390.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,675,321,283.03	1,802,070,222.29
210502	Хоол, хүнс	120,136,539.00	130,105,168.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,282,840.00	7,508,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,991,765.60	106,489,398.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,723,000.00	2,761,880.00
210604	Урсгал засвар	48,268,765.60	103,727,518.20
2107	Томилолт, зочны зардал	11,827,986.00	7,507,079.00
210702	Дотоод албан томилолт	11,827,986.00	7,507,079.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,745,937.40	35,399,207.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,446,920.00	4,588,002.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,168,000.00	2,044,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,971,899.60	5,260,525.08
210804	Тээврийн хэрэгслийн татвар	384,664.00	416,562.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	253,000.00	284,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,525,000.00	9,595,000.00

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	1,089,900.00	1,089,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,500.00	88,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,856,053.80	12,033,218.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,418,212,769.39	973,126,514.76
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,418,212,769.39	973,126,514.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,932,007.47	24,111,099.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,884,000.00	18,045,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,774,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,110,000.00	18,045,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,066,099.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,066,099.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	264.07	00.00
213404	Хөрөнгийн	264.07	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,047,743.40	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,047,743.40	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>656,833,787.46</u>	<u>2,025,895,936.24</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	135,308,333.39
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	135,308,333.39
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-135,308,333.39
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>656,833,787.46</u>	<u>1,890,587,602.85</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>6,830,530,642.71</u>	<u>8,974,724,193.74</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>163,758,419.00</u>	<u>272,180,899.74</u>
120	Нийтлэг татварын бус орлого	163,758,419.00	272,180,899.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	158,278,419.00	265,644,999.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,278,419.00	265,644,999.74
120009	Бусад орлого	5,480,000.00	6,535,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>6,666,772,223.71</u>	<u>8,702,543,294.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,271,334,600.00	4,538,634,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,271,334,600.00	4,538,634,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	171,507,799.71	523,825,539.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	300,000.00

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	67,287,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	438,507,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,507,799.71	17,729,839.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,223,929,824.00	3,640,083,155.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,223,929,824.00	3,640,083,155.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,808,532,742.71	8,886,649,313.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,808,532,742.71	8,886,649,313.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,792,600,735.24	8,862,538,214.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,872,001,995.53	4,693,191,806.00
210101	Үндсэн цалин	2,006,319,886.00	2,191,474,502.35
210102	Нэмэгдэл	1,551,847,257.53	2,010,991,712.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	190,240,972.00	185,525,409.41
210104	Урамшуулал	123,593,880.00	305,200,182.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	461,243,361.00	690,398,325.37
210201	Тэтгэврийн даатгал	315,100,761.00	516,107,425.37
210202	Тэтгэмжийн даатгал	36,535,700.00	43,572,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,228,500.00	34,858,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,307,100.00	8,714,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	73,071,300.00	87,145,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	765,182,900.00	1,005,335,512.02
210301	Гэрэл, цахилгаан	97,426,472.82	121,585,182.20
210302	Түлш, халаалт	550,544,600.00	666,899,378.00
210303	Цэвэр, бохир ус	117,211,827.18	216,850,951.82
2104	Хангамж, бараа материалын зардал	129,025,850.11	135,187,427.61
210401	Бичиг хэрэг	11,406,089.00	15,756,650.00
210402	Тээвэр, шатахуун	55,163,827.00	40,667,204.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,484,270.11	6,890,456.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,614,900.00	27,771,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,356,764.00	44,101,616.00
2105	Нормативт зардал	1,443,732,300.00	2,172,456,982.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,294,995,200.00	2,022,501,752.46
210502	Хоол, хүнс	119,802,450.00	131,071,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,934,650.00	18,883,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,186,649.00	121,712,931.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,573,800.00	7,886,980.00
210602	Тавилга	3,200,000.00	5,085,000.00

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,031,300.00	732,600.00
210604	Урсгал засвар	58,381,549.00	108,008,351.20
2107	Томилолт, зочны зардал	11,827,986.00	7,507,079.00
210702	Дотоод албан томилолт	11,827,986.00	7,507,079.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,399,693.60	36,748,151.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,407,550.00	4,624,002.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,168,000.00	2,044,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,971,899.60	5,260,525.08
210804	Тээврийн хэрэгслийн татвар	384,664.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	253,000.00	284,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,275,000.00	9,330,000.00
210807	Газрын төлбөр	1,089,900.00	1,089,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,500.00	88,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,799,180.00	13,627,724.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,932,007.47	24,111,099.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,884,000.00	14,646,379.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,774,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,110,000.00	14,646,379.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	9,464,720.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,464,720.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	264.07	00.00
213404	Хөрөнгийн	264.07	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,047,743.40	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,047,743.40	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>21,997,900.00</u>	<u>88,074,880.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>22,691,900.00</u>	<u>85,298,980.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>22,691,900.00</u>	<u>85,298,980.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	22,691,900.00	85,298,980.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,691,900.00	85,298,980.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-22,691,900.00</u>	<u>-85,298,980.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-694,000.00	2,775,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,018,750.00	324,750.00

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	324,750.00	3,100,650.00
----	---	------------	--------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,532,071,275.49	5,355,745,575.92	-316,648,916.06	9,571,167,935.35
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,532,071,275.49	5,355,745,575.92	-316,648,916.06	9,571,167,935.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,532,071,275.49	5,355,745,575.92	-316,648,916.06	9,571,167,935.35
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,890,587,602.85	1,890,587,602.85
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,532,071,275.49	5,355,745,575.92	1,573,938,686.79	11,461,755,538.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,861,856,800.00	8,438,296,655.74	423,560,144.3	95.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,861,856,800.00	8,438,296,655.74	423,560,144.3	95.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,856,476,800.00	8,433,301,655.74	423,175,144.3	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,536,427,400.00	4,536,427,400.00	-	100.0
210101	Үндсэн цалин	2,142,112,000.00	2,191,474,502.35	(49,362,502.3)	102.3
210102	Нэмэгдэл	1,932,009,600.00	1,854,227,306.24	77,782,293.8	96.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	176,288,000.00	185,525,409.41	(9,237,409.4)	105.2
210104	Урамшуулал	286,017,800.00	305,200,182.00	(19,182,382.0)	106.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	588,231,900.00	588,231,900.00	-	100.0

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	413,941,000.00	413,941,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	43,572,700.00	43,572,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,858,200.00	34,858,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	8,714,500.00	8,714,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	87,145,500.00	87,145,500.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,110,676,300.00	1,005,335,512.02	105,340,788.0	90.5
210301	Гэрэл, цахилгаан	134,400,600.00	121,585,182.20	12,815,417.8	90.5
210302	Түлш, халаалт	745,648,400.00	666,899,378.00	78,749,022.0	89.4
210303	Цэвэр, бохир ус	230,627,300.00	216,850,951.82	13,776,348.2	94.0
2104	Хангамж, бараа материалын зардал	131,924,200.00	131,611,648.54	312,551.5	99.8
210401	Бичиг хэрэг	13,150,300.00	14,544,350.00	(1,394,050.0)	110.6
210402	Тээвэр, шатахуун	41,756,200.00	40,667,204.98	1,088,995.0	97.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,320,000.00	6,890,456.63	429,543.4	94.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000,000.00	27,771,500.00	2,228,500.0	92.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,697,700.00	41,738,136.93	(2,040,436.9)	105.1
2105	Нормативт зардал	2,351,096,500.00	2,042,245,225.10	308,851,274.9	86.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,196,602,900.00	1,892,289,995.10	304,312,904.9	86.1
210502	Хоол, хүнс	125,550,000.00	131,071,250.00	(5,521,250.0)	104.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,943,600.00	18,883,980.00	10,059,620.0	65.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,396,600.00	85,890,890.00	2,505,710.0	97.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,880,500.00	13,321,880.00	558,620.0	96.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	732,600.00	1,767,400.0	29.3
210604	Урсгал засвар	72,016,100.00	71,836,410.00	179,690.0	99.8
2107	Томилолт, зочны зардал	8,700,000.00	7,255,079.00	1,444,921.0	83.4
210702	Дотоод албан томилолт	8,700,000.00	7,255,079.00	1,444,921.0	83.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,023,900.00	36,304,001.08	4,719,898.9	88.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,456,000.00	4,197,852.00	1,258,148.0	76.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,044,000.00	2,044,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	7,971,900.00	5,260,525.08	2,711,374.9	66.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	286,000.00	284,000.00	2,000.0	99.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,330,000.00	9,330,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,089,900.00	1,089,900.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	70,000.00	70,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,376,100.00	13,627,724.00	748,376.0	94.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5380000.00	4995000.00	385,000.0	92.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,380,000.00	4,995,000.00	385,000.0	92.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,380,000.00	4,995,000.00	385,000.0	92.8

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,861,856,800.00	8,438,296,655.74	423,560,144.3	95.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,538,634,600.00	4,532,568,501.00	6,066,099.0	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,538,634,600.00	4,532,568,501.00	6,066,099.0	99.9
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,049,364,300.00	3,640,083,155.00	409,281,145.0	89.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,049,364,300.00	3,640,083,155.00	409,281,145.0	89.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	273,857,900.00	265,644,999.74	8,212,900.3	97.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	273,857,900.00	265,644,999.74	8,212,900.3	97.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	524,186,918.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,186,918.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,535,539.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,764,406.00
210102	Нэмэгдэл	156,764,406.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,166,425.37
210201	Тэтгэврийн даатгал	102,166,425.37
2104	Хангамж, бараа материалын зардал	3,575,779.07
210401	Бичиг хэрэг	1,212,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,363,479.07
2105	Нормативт зардал	130,211,757.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,211,757.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,121,021.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,296,100.00
210602	Тавилга	41,652,980.00
210604	Урсгал засвар	36,171,941.20
2107	Томилолт, зочны зардал	252,000.00
210702	Дотоод албан томилолт	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	426,150.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	18,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9651379.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,651,379.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,651,379.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	530361439.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	530,361,439.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	300,000.00

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,287,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	438,507,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,265,739.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Анхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авах ажиллагаа, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, засвар, үйлчилгээ, дотоод хяналт, бодлого үйл ажиллагаанд анхаарах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 80 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн ам ялангуяа эх, хүүхэд, ядуу эмзэг бүлгийн иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хамралт, ашиглалтыг нэмэгдүүлэх.
- Эм зүй ба дэмжих үйлчилгээ
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар
- Эрүүл мэндийн санхүүжилт
- Хүний нөөцийн хөгжил
- Зан үйлийн өөрчлөлт ба харилцаа гэсэн үндсэн 6 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “ журам батлах тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн 11,645,589.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 116,455.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,637,426.0 мянган төгрөгөөр буюу 16.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	324.7	3,100.7	2,776.0
Авлага	36,696.9	40,161.6	3,464.7
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	448,263.2	647,926.8	199,663.6
Үндсэн хөрөнгө	9,522,878.5	10,954,400.1	1,431,521.6
Нийт хөрөнгө	10,008,163.3	11,645,589.2	1,637,425.9
Өр төлбөр	436,995.4	183,833.7	-253,161.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,571,167.9	11,461,755.5	1,890,587.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,008,163.3	11,645,589.2	1,637,425.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,100.7 мянган төгрөг болж 2,776.0 мянган төгрөгөөр өссөн нь Нэгдсэн эмнэлгийн Ахмадын сангийн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 40,161.6 мянган төгрөг болж өмнөх оноос 3,464.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 07/24 тоот албан бичгийн дагуу хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон ажилтнуудын суутгалыг буцаан олгох болсон, жилийн эцэст хийгдсэн урамшууллын гүйлгээ буцсаныг Сангийн яам татсаныг авлагаар тусгасан, бараа материалын худалдан авалт, засвар үйлчилгээний захиалгын авлага зэргээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2012, 2019 онуудад үүссэн, он удаан жил болсон 12,329.0 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 647,926.8 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 199,663.6 мянган төгрөгөөр өсөхөд тайлант онд шинээр 2,240,798.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч тусламж үйлчилгээнд 2,173,068.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд удаан жил хадгалагдсан, ашиглалтгүй бараа материал байхгүй бөгөөд нийт бараа материалын дансны үлдэгдэл хөрөнгийн 28.2 хувь буюу 182,586.2 мянган төгрөг нь агуулахад бүртгэлтэй, 71.8 хувь буюу 465,340.6 мянган төгрөг нь эд хариуцагчид бүртгэлтэй хөрөнгө байна. Няравын агуулахад бүртгэлтэй хөрөнгийн 62.2 хувь буюу 113,510.5 мянган төгрөгийн эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл эзэлж байна. Энэ нь дараагийн төсвийн жилийн санхүүжилт эхэлтэл тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангах, төрийн үйлчилгээг ард иргэдэд саадгүй хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагаар тодорхойлогдоно. Мөн болзошгүй гамшгийн бэлэн байдлыг хангахад эм хэрэгсэл, бараа материалын нэг сарын нөөцтэй байх шаардлагатай байдаг.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18,396,958.6 мянган төгрөг болж 2,176,300.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийсэн 85,299.0 мянган төгрөг, оны эхний авлага барагдуулж 5,700.0 мянган төгрөг, салбарын хөрөнгө оруулалтаар 612,415.2 мянган төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,802,600.4 мянган төгрөг, төсөл хөтөлбөрөөр, хандив тусламжаар 35,478.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгийн данснаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 222,500.0 мянган төгрөг, акталсан 141,156. мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 183,833.7 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеийн үлдэгдлээс 253,161.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны батлагдсан төсвөөс өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулж, оны дундуур хуримтлагдсан өглөг үүсээд байсан эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд ЭМЯ-аас нэмэлт төсөв хуваарилагдсан нь нөлөөлсөн.

Нийт өглөгийн 42.8 хувь буюу 78,748.8 мянган төгрөгийг түлш халаалтын зардлын, 47.0 хувь буюу 86,323.8 мянган төгрөгийг эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлын, 8.2 хувь буюу 15,112.6 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон ажилтнуудад буцаан олгох ХХОАТ-ын өглөг, 1.8 хувь буюу 3,398.6 мянган төгрөгийг оны эцэст хийж чадаагүй урамшууллын гүйлгээ, 0.1 хувь буюу 250.0 мянган төгрөгийг тээврийн хөлсөнд төлөх өглөг эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрт байхгүй.

Өр төлбөр дансны үлдэгдэлд өмнөх онуудын хуримтлагдсан өглөг, барьцаа хөрөнгө байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,461,755.5 мянган төгрөг болж өмнөх оноос 1,890,587.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,191,078.3 мянган төгрөгөөр буюу 23.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 106,636.1 мянган төгрөг буюу 67.0 хувиар өссөн байна. Энэ нь батлагдсан төсвийг өмнөх оноос 119,857.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 822,016.2 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, АОНДШ, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, урсгал засварын зардлууд байна.

Энэ нь цалин нэмэгдэл АОНДШ-д 1,036,381.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шалтгаалсан байна. Ажиллагсдын мөнгөн урамшууллын сарын дээд хязгаар 15 хувь байсныг 20 хувь болгож өөрчилсөн ба ажлын үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгосон, шинэ коронавирусын өвчлөл улс орон даяар цар тахал байдлаар гарч эмч эмнэлгийн ажилтнууд бэлэн байдал хангах, өвчний голомтод зэргээр илүү цагаар ажиллах зайлшгүй шаардлага гарсан. Мөн эмнэлгийн дотоод зохион байгуулалтад өөрчлөлт оруулж халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг тусад нь байрлуулах тусгаарлах байр, тасгийг шинээр нээхтэй холбоотойгоор эм бэлдмэл, эмнэлгийн болон хамгаалах хувцас хэрэгслийн хэрэгцээ нэмэгдсэн, байрны тохижилт засвар үйлчилгээ хийх зайлшгүй шаардлага гарсан зэрэг нь нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 10,789,574.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 10,789,574.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,945,160.9 мянган төгрөгөөр бууруулж 7,844,413.2 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант оны дундуур батлагдсан төсөвт 7 удаа өөрчлөлт оруулснаар оны эцэст 8,861,856.0 мянган төгрөг болж оны эхэнд батлагдсан төсвөөс 1,017,443.6 мянган төгрөг нэмж батлагдсан.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 36 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,861,856.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,538,634.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,049,364.3 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 273,857.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,538,634.6 мянган төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас 3,640,083.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 265,645.0 мянган төгрөг, нэмэлт болон бусад орлогоор 523,825.5 мянган төгрөг, нийт 8,968,188.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 8,962,122.2 мянган төгрөгийг зарцуулж 6,066.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,962,122.2 мянган төгрөг, үүнээс урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 8,438,296.7 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 105,340.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 308,851.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 2,505.7 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийн зардлыг 4,719.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг 385.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн төлөвлөгөө 409,281.1 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 8,212.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 300.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт аймгийн ИТХ, Засаг дарга, Сайншанд сумын Засаг даргын захирамжаар олгосон санхүүгийн дэмжлэгээр 67,287.8 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 438,507.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 24,265.7 мянган төгрөг нийт 530,361.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нэмэгдэл АОНДШ-д 258,930.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3,575.8 мянган төгрөг, нормативт зардалд 130,211.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 121,121.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 252.0 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардалд 444.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 9,651.4 мянган төгрөг нийт 524,186.9 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 605,480.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 241,871.3 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг хангахаар ажилласан байна. Түлш халаалтын зардлын төсвийг тайлант оны дундуур 95,438.4 мянган төгрөгөөр нэмж батлуулсан боловч тусламж үйлчилгээний гүйцэтгэл бүрэн хангагдаагүйгээс эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн төлөвлөгөө тасарч дулааны төлбөрт өглөгтэй гарч тооцоо нийлсэн актаар баталгаажуулж тайлагнасан. Оны эхний авлагаас барагдуулаагүй үлдэгдэл 12,329.0 мянган төгрөг буюу 33.7 хувийг барагдуулаагүй.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0	0	0
Албан шаардлага	3	605,480.5	2	593,151.5	1	12,329.0	2.03
Зөвлөмж	1	241,871.3	1	241,871.3	0	0	0
Нийт дүн	4	847,351.8	3	835,022.8	1	12,329.0	2.03

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 99,993.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 719.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,329.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 86.944.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, элэгдэл бодуулаагүй 1 нэр төрлийн 4 ширхэг 719.6 мянган төгрөгийн хөрөнгөнд ашиглах жил, элэгдлийг оруулан залруулсан.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 76,944.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг ЭМГ болон бусад дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүйгээр хөрөнгө ирүүлдэг боловч тооцоо нийлж баталгаажуулж ажиллахгүй байгаа тул хөрөнгийн бүртгэл, хадгалалт, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон баримтыг хариуцсан тоног төхөөрөмжийн инженер нь боловсруулдаггүй мөн уг асуудлын талаар байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцдэггүй байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хөрөнгө алдагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйл 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйл 13.4-т “аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан

шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй:”1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол 7 дугаар зүйл “хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.5 “хэмжигдэхүйц байх” гэж тус тус заасан байдаг тул худалдан авах болон засварлах хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тогтоож холбогдох хууль, журмын дагуу данс бүртгэлд тусгаж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлогоос 12,471.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

2.2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг зөрчих, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

2.3. Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг үдирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 47 дугаар зүйл 47.1-т “Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно” Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-д тус тус заасан тул үйл ажиллагаанаас олох орлогыг үндсэн дансаар дамжуулан зохих журмын дагуу зөвшөөрлөө авч, тушаал шийдвэрээр зарцуулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:Тендер зарлаж шалгарсан бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг мөрдөж ажиллаагүй байна.

3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, өрсөлдөөнийг хязгаарлах.

3.3 Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, тендерийн жишиг баримт бичиг “ гэрээний ерөнхий нөхцөл”-д тус тус заасан байдаг тул бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг мөрдөж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Цалингийн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Орон нутагт ажилласны нэмэгдлийг байгууллагын жолооч нарт олгосон байна.

4.2 Эрсдэл: Нэмэгдэл олгох журмыг зөрчсөн байна.

4.3 Монгол Улсын Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт “ төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д тус тус заасан байдаг тул цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж жолооч нарт орон нутагт ажилласны нэмэгдлийг олгохгүй байх.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: Аймгийн Нэгдсэн эмнэлгээс сүмдын Эрүүл мэндийн байгууллагуудад хүчил төрөгч болон бусад материалыг нийлүүлэх зохицуулалт хийсэн боловч үг зардлаас төвлөрсөн орлогыг зардал бууруулсан байна. Мөн ЭМГ-с дэмжлэгээр ирсэн шатахууны мөнгийг зардал бууруулсан байна.

5.2 Эрсдэл: Санхүүгийн тайлангийн бодит гүйцэтгэл, илэрхийлэл алдагдах.

5.3 Монгол Улсын Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-т заасан байдаг тул цаашид холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж төсөвт байгууллагаас олгосон дэмжлэгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан орлого болон зардлыг бууруулах бичилт хийхгүй мэдээ, тайланд бүрэн түсгэж ажиллах.

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/122/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Олон жил болсон авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч шийдвэрлээгүй.	12,329.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
2	Аймгийн Нэгдсэн эмнэлгээс Сумдын эрүүл мэндийн байгууллагуудад хүчил төрөгч болон бусад материалыг нийлүүлэх зохицуулалт хийсэн боловч уг зардлаас төвлөрсөн орлогыг зардал бууруулсан байна. Мөн ЭМГ-с дэмжлэгээр ирсэн шатахууны мөнгийг зардал бууруулсан байна.	11,912.8	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
3	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон баримтыг хариуцсан тоног төхөөрөмжийн инженер нь боловсруулдаггүй мөн уг асуудлын талаар байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцдэггүй байна.	62,560.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
4	Үйл ажиллагааны орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэхдээ зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна	12,471.4	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
5	Тендер зарлаж шалгарсан бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг мөрдөж ажиллаагүй байна	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
6	Орон нутагт ажилласны нэмэгдлийг байгууллагын жолооч нарт олгосон байна	0.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
7	Үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, элэгдэл бодуулаагүй 1 нэр төрлийн 4 ширхэг хөрөнгөд ашиглах жил, элэгдлийг оруулан залруулсан	719.6	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Г.Анхбаяр, Ц.Батсайхан
ДҮН		99,993.3			